

МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙ ДЭХ “ЗУРГАА ДАХЬ ЗАСАГЛАЛ”-ЫН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙД

Л.Норовсүрэн\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

**Түлхүүр үг:** засаглал, уламжлал, “Уриа”, өрнөдийн онол, Д.Нацагдорж, “Монголын сонин бичиг”, дэлхийн засаг, улсын засаг, шүүмжлэл, гэгээрэл, хүний эрх, колони, тусгаар тогтнол

**Э**нэ өгүүллийг тэрлэхийн өмнө гучин таван жилийн тэртээх нэг явдал санаанд буугаад байв. Юу гэвэл Монголын иргэн Жүгдэрдэмидийн Гүррагчаа сансарт нислээ гэж монголчууд биднийг бөөн баяр хөөр болж байхад БНХАУ-ын радиогийн монгол хэлний нэвтрүүлгээр «Монголчууд хэзээнээсээ нааш бусдын унаанд дайгдах дуртай улс байсан юм...» гээд цааш нь бас зөндөө юм ярьж билээ. Үнэн үг гашуун байдаг. Одоо бодоход тэр үг басамжилсан өнгө аястай боловч үнэний хувьтай байжээ. Уг хуучийг нэхэн санахын учир нь бид чинь бас бусдын үгээр үг хийж, түүнийгээ үнэний туйл болгон тоть шиг давтдаг болоо юу даа гэж хэлэх гэсэн хэрэг.

Хорь гаруй жилийн өмнө Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжиж,

дэлхий дахинд нээлттэй бодлого явуулж эхэлсэн нь бид бүхэнд эмээлийнхээ бүүрэгнээс цаашихыг харах боломж олгосон билээ. Гадаад ертөнцийн номлол, тэр тусмаа сэтгүүл зүйн олон янзын үзэл баримтлал нэвтрэн орж ирсний дотор «Сэтгүүл зүй бол дөрөв дэх засаглал мөн» гэсэн үзэл бидэнд цоо шинэ бөгөөд онцгой сэтгэгдэл төрүүлж, улмаар түүнийг яриа, бичгийн завсарт аль болох олон давтсан хүн л онолч юм уу, эсвэл сэтгүүл зүйн их чадвартан болж харагддаг болсоор удаж байна.

Гэтэл бид нөгөө л бусдыг даган дуурайдаг гүехэн сэтгэлгээгээрээ ахмад үеийнхнийхээ хурааж хуримтлуулж өгсөн оюуны их уурхайн амыг ч онгойлголгүй бусдын үгээр үг хийж хорь гаруй жилийг ардаа орхижээ. Юу гэвэл эдүгээгээс зуу шахам жилийн өмнө гарч байсан “Уриа” хэмээх сонин хэвлэл мэдээллийг «Зургаа дахь засаглал» гээд хэлчихсэн байх юм. Тэр үг бидний хэлэх дуртай дөрөв дэх засаглалын номлолоос илүү өргөн агуулгатай байсныг түүхийн шарласан хуудас бэлхнээ гэрчлээд өгнө.

Монголын хувьсгалчид эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж, гадаадын дарлал мөлжлөгөөс дөнгөж ангижраад илд мэс нь ч хөрөөгүй байсан 1921 онд шинэ Монгол улсын нам, төрийн албан ёсны ууган хэвлэл болж гарсан уг сонин хэвлэл мэдээллийн засаглалын хүрээ хязгаарыг хоёр шаттай авч үзэж байжээ. Нэгдүгээрт: хэвлэл мэдээлэл бол дэлхийн засаглал гэж үзсэн бол, хоёрдугаарт: улс орон бүхэнд хэрэгжих дотоод засаглал хэмээн үзэж байсан байна.

Хүн төрөлхтний өнгөрсөн үеийн түүх бол хатуухан хэлэхэд дэлхийн улс орнуудын хүчтэй нь хүчгүйгээ барьж идэж ирсний түүх билээ. Дайн түрэмгийлэл, колоничлол, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, их гүрнүүдийн дээрэнгүй бодлого, шашин хоорондын мөргөлдөөн, алан хядах, үзэн ядах, аймаглан устгах зэрэг харгис хэрцгий явдал хүн төрөлхтний түүхэнд байнга гарсаар ирсэн, гарсаар ч байгаа. Энэ бүхнийг тольдон харж, дэлхий нийтийн сонорт хүргэн ил тод болгож, зөвийг өмөөрч, бурууг баалж, харгисыг шүүмжилж, хохирсныг өмгөөлж байдаг сонин хэвлэл бол дэлхийг хуваан захирч ирсэн Орос, Герман зэрэг улсын таван их Засгийн газар дээр нэмэх зургаа дахь Засгийн газар мөн гэсэн үзэл онолыг бидний ахмад үе бичиг цаасанд мөнхлөн хоцроосон байна.

«Уриа» сонин анхныхаа дугаарт «Сонин бичгийн тус ашиг чадал нь нэн хэтэрхий их тул зарим нэгэн гадаадын эрдэмтэн дэлхийн бүх сонин бичгүүдийн газруудыг нийтлэн хамтатгаж Европын Орос, Англи зэргийн таван их улс лугаа адил мөн дэлхийн

зургадугаар их улс хэмээн өгүүлмүй. Зусарлан засч, бялдуучлан сөгдөх зүйлийг үл хэрэглэн хан, ван, ард хэмээн ялгалгүй тэд бүхнийг улс ба олон түмэнд хорт гэм явдал үүсгэвээс гагцхүү үнэнийг эрхлэн сэтгүүл буюу сонин бичгүүдийн зүгээс илэрхийлэн хэвлэж тунхаглахуйд ямар ч хэргэм тушаалтай хүмүүс зайлшгүй Улсын шүүх таслах газар лугаа уулзан олонд муу хэлэгдэн устмой. Иймийн учир сэтгүүл буюу сонин бичгийн хороонууд бүрэн эрхт Засгийн газар мэт ямар ч гажуу хүнийг буруудуулан устгах чадалтай тул энэхүү сэтгүүл буюу сонин бичгүүдийн газруудыг Зургадугаар дэлхийн их улс лугаа адилтгасан нь даан ч хоосон үг бус амой»<sup>1</sup> гэжээ. Энэ ишлэлээс үзэхэд дэлхийн бүх сонин хэвлэлүүд аливаа шударга бус явдлын эсрэг дуу хоолойгоо хамтатган тэмцвэл жинхэнэ зургаа дахь засаг болж чадна гэсэн санааг агуулж байжээ.

**Т**эд сонин хэвлэл бол улс үндэстэн бүхний дотоод засаглал мөн гэсэн үзэл санаагаа улс орны дотор болж байгаа цаг үеийн чухал үйл явдал, төр засгийн бодлого шийдвэр, ард олны аж амьдрал, ололт амжилт, тохиолдож байгаа бэрхшээл хүндрэл, тэдгээрийг даван туулах тэмцэл, хэрэгжүүлж байгаа арга замын зөв буруу бүхнийг нийтэд ил тод болгож, тэднээр шүүн хэлэлцүүлэх индэр болж байдгаараа ард түмний засаглалын үүргийг гүйцэтгэж байдгаар тайлбарлаж байжээ. Түүнчилэн тэд хэвлэл мэдээллийг ард түмнийг гэгээрүүлж боловсруулах хүчтэй засаглал гэж үзэж байсан байна. Энэ нь «Бүх үнэнч сонин

бичгүүдийн жинхэнэ алба нь харгис хуурмагийг уран хурц үгээр нэвтэртэл сэнхрүүлэн олонд толилуулан, умартсаныг сануулан олон түмний ба улс төрийн ашиг тусыг чухал болгон хичээх тул мөн манай "Уриа" хэмээх сэтгүүл олон ард ба цэргийг боловсруулах хэргийг гол болгон эрхлэх боловч улс төрийн ба олон түмний ашиг тусыг харгалзан чармайж хичээн, цэрэг ба олон түмний бүх ядрал зовлонг Засгийн газар ба олны өмнө илрүүлж, үнэхээр ард ба олон цэргийн сэтгүүл болохыг хүсмүй. Тиймийн тул хэн дарлагдсан, хохирсон ард буюу цэрэг буй аваас шууд манай сэтгүүлийн хорооноо ирж өөрийн ядрал хохирлоо сонсгож байваас зохимой»<sup>2</sup> гэж бичсэнээс тодорхой байна.

«Уриа» сонины дараа гарсан томоохон сонин болох «Ардын эрх» сониныг эрхлэн гаргагчид хэвлэл мэдээллийг мөн л засаглалын хүчтэй хэрэгсэл хэмээн үзэж, түүний ач холбогдлыг өндөр үнэлж байжээ. Тус сонин 1924 оны 2 дугаар сарын 5-нд гарсан анхныхаа дугаарт нийтэлсэн «Манай зорилго» хэмээх редакцийн өгүүлэлдээ «Байцааваас аливаа улсын засгийн хэргийг явуулахад цөм бусад гадаад улсын төрийн явдал ба өөрийн дотоод байдлыг хянаж, цаг зүйд

нийлүүлэн явуулах тул ямагт сонин чухал зүйлийг хураангуйлан мэдэхийг гол болгосугай!» гэж зорилгоо тодорхойлоод, «Улсын байдлыг хянаж, олон түмний аж ахуй, эрдэм соёлыг хөгжүүлэн дэлгэрүүлэх явдлыг үүсгэн хөдөлгөхүйд түүний ашиг тусыг тайлбарлан, бүгдээрээ харилцан санал онолыг гаргаж шүүмжлэн дөхмийг эрж, ашиг шимийг олохыг эрхэмлэн, эл хэргийн учир харьяат улсын Засгийн

газраас тогтоосон, шийтгэсэн хууль дүрмийн зарлалыг тайлбарлан нэвтрүүлэх нь чухал тул гагцхүү сонин сэтгүүлд итгэсүгэй!»<sup>3</sup> гэж төрийн хэрэг, улсын явдалд тогтмол хэвлэлийн гүйцэтгэх үүргийг онцгойлон үнэлсэн байна.

Тус сонин бас «Улсын дотор

бүхий үнэн шударга бусыг арилгаж, шударга сайныг хөгжүүлэхийг хүсэх хийгээд ... ерийн ухааны эрдмийн ач тусыг шүүмжлэн өгүүлэлдэж, онц сонин гайхамшигтай зүйлийг гаргаж сонирхуулах ба ард иргэдийн хэрхэн энх амар байх явдлыг шүүмжлэн, бузар бургтгийн хорыг тайлбарлан, учир шалтгааныг зааж туслахыг үндэс болгох»<sup>4</sup> нь хэвлэлийн үүрэг гэж үзсэн байна. Энд дурдсан агуулгыг нягтлан үзэхүл сонин гаргагчид тогтмол хэвлэл бурууд нүд хурц, зөвд сэтгэл зөөлөн байж, ард иргэдийг амар тайван, аз

«

*Хэвлэл бол уншигч олон түмэнд чухал хэрэгтэй үнэн бодит мэдээллийг тэдний сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй түгээх замаар олон түмнийг гэгээрүүлж, хүмүүжүүлдэг төдийгүй, эрх баригч хүчний буруу үйлдэлд даралт шахалт үзүүлдэг хэрэгсэл мөн бөгөөд, энэ үүргийг аль болох олон нийтийн санаа бодлыг уралдуулж, тэдний хэвлэн нийтлэх эрх чөлөөг бодитой хангах зарчмаар хэрэгжүүлэх ёстой*

»

жаргалтай байлгахын тулд төр засгийг буруу үйл хийлгэхгүй байх «хоточ нохой»-н үүрэгтэйг дам хэлээд авсан нь илэрхий байна.

«Ардын эрх» сонин «Түмэн иргэний эрх чөлөөг хэрхэн бататгах, хилс дарлагдсан ардын ашиг тусыг хамгаалах» асуудлыг эрхэм зорилгоо болгож, «Гадаад лугаа хэрхэн харилцах хийгээд цэргийн явдлыг хэрхэн сайжруулах, боловсруулах зэргийг шүүмжлэн тайлбарлах»-ыг чухалчилж байгаагаа илэрхийлсэн зэргээс үзвэл хэвлэлийг улс төрийн хэрэгт санал онолоо нэмэрлэж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зэрэгт улс орны эрх барих хүчинд хавсран зүтгэх албан бус засаглал мөн хэмээн үзэж байсан нь илэрхий байна.

**С**онин хэвлэлийн засаглалын хийгээд соён гэгээрүүлэх, илчлэн шүүмжлэх үүргийг өндөрт өргөж, ингэснээр төрийг тунгалаг байлгах асуудлыг сөхөн тавьж байсан баримтууд хуучин хэвлэлийн хуудсанд арвин байдаг. Эдүгээгээс 110 шахам жилийн өмнө гарч байсан «Монголын сонин бичиг» сонин «Сонин гэгч нь дотоод, гадаад олон улсын сонин хачныг нягт сурвалжилж, бүрнээр гаргаж бичих тул алив хүний сонсголыг маш уудамтган, оюуныг нээгдүүлнэ. Тийнхүү сонин бичиг үзэх авхай нар үүдээрээ гараагүй байж ертөнцийн сонинь хэнхдэг дотроо агуулна»<sup>5</sup> гэж сонин хэвлэлийн гэгээрүүлэгч үүргийг маш оновчтой тодорхойлсон байна. Монголын үндэсний дэвшилт ардчилсан тогтмол хэвлэлийн нэг болох «Нийслэл Хүрээний сонин бичиг» сонин дээр дурдсан тогтмол хэвлэлүүдийн нэгэн

адил хэвлэлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, гэгээрүүлэх, илчлэн шүүмжлэх чиглэлийг тэргүүн зэрэгт тавьж байжээ. Тус сонины анхдугаарт гарсан «Сонсгол» гэсэн гарчигтай сонордуулгад «Олон бүхнээр дэлхий дахины элдэв сонин үзэсгэлэн сонсголыг мэдэж ээрэх дур үлэмж байгаа болохоор үсэг нэрлэгчид сонирхон үзсээр сонинд дурлаж, үсэг эрдэмд нэвтэрхий суралцахыг бодож сонин бичгийг тусгайлан дармалласан тул олон монголчууд захиалан авахын дээр хилс буруу учир дарлагдсан тухай үнэн зүйлийг шүүмжлэн нийтлүүлэх бол манай сонин бичгийн хороонд хэлэлцэн өгөөд хэвлүүлж болорх учрыг сонсгоё»<sup>6</sup> гэсэн байдаг.

Энэ нь хэвлэл бол уншигч олон түмэнд чухал хэрэгтэй үнэн бодит мэдээллийг тэдний сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй түгээх замаар олон түмнийг гэгээрүүлж, хүмүүжүүлдэг төдийгүй, эрх баригч хүчний буруу үйлдэлд даралт шахалт үзүүлдэг хэрэгсэл мөн бөгөөд, энэ үүргийг аль болох олон нийтийн санаа бодлыг уралдуулж, тэдний хэвлэн нийтлэх эрх чөлөөг бодитой хангах зарчмаар хэрэгжүүлэх ёстой. Ингэсэн нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон түмнээр өөрийгөө хүрээлүүлж амьдрах чадалтай, амьд сонирхолтой болно хэмээн үзэж байсныг харуулж байна. Эцэст нь эдгээр ишлэлүүдийн агуулгыг бүхэлд нь авч үзвэл хэвлэл мэдээлэл бол засаглалын үүргийг үйл ажлаар биш ч гэсэн үг хэлээр хэрэгжүүлдэг зүй тогтлыг Монголын ууган сэтгүүлчид сайн мэдэж байжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Засаглалын үүргийг хэрэгжүүлэгч тогтмол хэвлэлийн ач тус хийгээд түүнийг эрхлэн гаргахад анхаарах зүйлүүдийн талаар хорь, гучаад онд өргөн сурталчилгаа өрнүүлж байсан нь ч санамсаргүй хэрэг биш байлаа. Учир нь нийгмийн шилжилтийн эгзэгтэй үед түүнийг хөдөлгөгч гол хүч болсон олон түмэнд шинэ нийгмийн зорилго, үйл хэргийг сурталчлан тайлбарлаж, улмаар төр засгийн бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч иргэд болгон хүмүүжүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг асар их байсан юм.

Энэ үед Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ч.Дашням, Ши. Аюуш нарын зэрэг соён гэгээрүүлэгчид сонин хэвлэлийн ач холбогдлыг тайлбарлаж, нийтлэл мэдээллийг чанаржуулах талаар үнэтэй үгийг хэлцгээж байжээ. Зөвхөн тухайн үеийн «Үнэн» сонинд л гэхэд «Сонин ба сонинд бичигчид», «Сонин сурвалжлагчид», «Сонин бичигт мэдээ шүүмжлэл бичих тухай сануулах нь» гэх зэрэг олон өгүүлэл, зөвлөмж нийтлэгдсэн байна.

Д.Нацагдорж сонин хэвлэлийн ач тус, үүрэг зорилгыг өгүүлсэн олон нийтлэг өгүүлэл бичсэний дотор «Сонин ба зохиолч» гэдэг өгүүлэлдээ «Эдүгээ үед улс гүрнүүд сонин сэтгүүлээр бүрхэгдэж, сонин сэтгүүл нь дэлхийг бужигнуулан буй бөгөөд, энэхүү шинэ цагийн сонин сэтгүүлгүйгээр шинэ ертөнц тогтнож чадахгүй болой. Нэгэн хэдэн үгээр түүний учрыг товч тайлбарлавал, сонин бичиг бол нийтийн сонирхож буй зүйлийг бүртгэх, эрж буй зүйлийг олгох ба олон ардыг нийтийн байдал лугаа танилцуулан холбоно. Энэ мэтээр сонин нь боловсон улсад өглөө бүр дэлхийг

харах толь лугаа буй»<sup>7</sup> гэж сонин хэвлэлийн мэдээлэх, соён гэгээрүүлэх үүргийг онцолсон байдаг. Өргөн утгаар нь авч үзвэл түүний энэ үг мөн л засаглалын үүрэгтэй холбогдож байгааг анзаарч болно. Учир нь олон түмэн хэдийчинээ их мэдлэг, мэдээлэлтэй байхын хэрээр дэлхий ертөнцийн байдлыг танин мэдэж, тэр жишгээр өөрийн орны байдалд үнэлэлт дүгнэлт хийж, улмаар учир дутагдалтай зүйлийг илчлэн шүүмжлэх замаар эрх баригчдад санаа сэрэмж өгч олон нийтийн засаглалын үүргээ хэрэгжүүлдэг билээ. Дээр дурдсан жишээнүүдээс үзэхэд манай сэтгүүл зүйн ахмад зүтгэлтнүүд хэвлэл мэдээллийг даян дэлхийн хүрээнд ч, дангаар орших улсын дотор ч үнэн шударгыг тогтооход юугаар ч орлуулшгүй хүчирхэг засаглал мөн хэмээн үзэж байсан нь тодорхой байна.

**Д**элхий нийтийн жишигтэй харьцуулахад монголчууд тогтмол хэвлэлийг харьцангуй хожуу эрхлэх болсон хэдий ч, өнгөрсөн зуу гаруй жилийн дотор өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг амдан хөгжиж, тэрхүү туршлагыг үндэснийхээ бичиг соёлын уламжлалтай зохистой хослуулах замаар өнөөгийн хөгжингүй сэтгүүл зүйн өндөрлөгт хүрч чадсан билээ. Эцэст нь тэмдэглэхэд өвөг дээдсийн үлдээж өгсөн ном соёлын арвин их өв уламжлал, ахмад сэтгүүлчдийн арга туршлага, үзэл баримтлал, хуучин сонин хэвлэлийн нийтлэлийн цэцэн мэргэн санааг ухан төнхөж, цөлбөн судалж үйл ажиллагаандаа ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг зориуд тэмдэглэе.

**Ишлэл**

- <sup>1</sup> «Уриа» сонин. 1921. № 1
- <sup>2</sup> «Уриа» сонин. 1921. № 1
- <sup>3</sup> «Ардын эрх» сонин. 1924. № 1
- <sup>4</sup> «Ардын эрх» сонин. 1924. № 1
- <sup>5</sup> «Монголын сонин бичиг». 1909. № 1
- <sup>6</sup> «Нийслэл Хүрээний сонин бичиг». 1915. № 1
- <sup>7</sup> «Үнэн» сонин. 1936. № 99

**Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. *Норовсүрэн Л.* 2004. Монголын нийтлэл. I боть. УБ.
2. *Норовсүрэн Л.* 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I боть. УБ.
3. *Норовсүрэн Л.* 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ.
4. “Уриа” сонин. 1921.
5. “Ардын эрх” сонин. 1924.
6. “Монголын сонин бичиг”. 1909.
7. “Нийслэл Хүрээний сонин бичиг”. 1915.
8. “Үнэн” сонин. 1936.
9. “Ардын үндэсний эрх” сонин. 1937.